

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН САЙДЫГ ТОМИЛУУЛАХ АСУУДЛААРХИ НИЙГМИЙН БОДЛОГО,  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 10 дугаар  
сарын 17-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар Цэдэнбалын Цогзолмааг томилуулахаар 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.6 дахь заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Ерөнхий сайдын дээрх саналыг хэлэлцлээ.

Цэдэнбалын Цогзолмаа нь багш, эрх зүйч мэргэжилтэй, ажлын гараагаа өөрийн эзэмшсэн мэргэжлийн дагуу Ховд аймаг дахь Багшийн дээд сургуулийн нийгмийн ухааны факультетэд багшилснаар эхэлсэн бөгөөд төрийн байгууллагад олон жил ажиллаж, туршлага хуримтлуулсан, төрийн ажил хэргийн өндөр мэдлэг, чадварыг эзэмшсэн. Удирдахуйн ухааны магистр, боловсролын удирдлагын докторант.

Цэдэнбалын Цогзолмааг Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар томилохыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.


Үүнтэй холбогдуулан Гэлэгпилийн Чулуунбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн боловсруулж, "Засгийн газрын зарим гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг оруулахаар тогтсон болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдыг томилуулах тухай асуудлаархи Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**Л.ЭНХ-АМГАЛАН**